



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/12/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:
Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518398, Факс: 70518398
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤ ᠠᠶᠢᠮᠦᠭ᠎ᠠ ᠳᠠᠬᠤ
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠤᠳᠢᠲᠢᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ
ᠲᠠᠨᠠᠶᠢ _____ -ᠨᠢᠶᠢ № _____ -ᠲ

СҮХБААТАР АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
О.БАЛЖИННЯМ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	145,415,080.46	122,751,678.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	20,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	20,000.00
31110	Төгрөг	0.00	20,000.00
33	АВЛАГА	39,377.44	0.00
335	Бусад авлага	39,377.44	0.00
3351	Байгууллагаас авах авлага	39,377.44	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	145,375,703.02	122,731,678.61
351	Түүхий эд материал	38,346,317.42	26,989,099.64
35130	Эм боох материал	38,346,317.42	26,989,099.64
354	Хангамжийн материал	107,029,385.60	95,742,578.97
35410	Бичиг хэргийн материал	8,157,706.89	6,192,177.76
35420	Аж ахуйн материал	7,446,977.71	8,529,071.71
35430	Сэлбэг хэрэгсэл	4,113,700.00	2,491,000.00
35440	Түлш, шатах тослох материал	13,538,000.00	2,390,000.00
35470	Бусад хангамжийн материал	73,773,001.00	76,140,329.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	473,611,535.39	435,794,067.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	473,611,535.39	435,794,067.66
392	Биет хөрөнгө	367,750,512.44	330,630,577.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	126,212,304.00	126,212,304.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,823,039.88	-22,038,701.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,280,000.00	81,280,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,723,176.89	-58,719,069.09
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	560,996,532.86	584,048,712.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-356,399,011.28	-409,198,915.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,049,880.64	40,459,880.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,398,688.91	-34,635,030.85
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,125,536.00	32,443,476.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,569,824.10	-9,222,079.05
393	Биет бус хөрөнгө	105,861,022.95	105,163,489.70
39301	Програм хангамж	6,297,078.00	6,297,078.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,161,055.05	-3,858,588.30
39303	Бусад биет бус хөрөнгө	102,725,000.00	102,725,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	619,026,615.85	558,545,746.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	498,961.28	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	498,961.28	0.00
413	Өглөг	498,961.28	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	498,961.28	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	618,527,654.57	558,545,746.27
51	Засгийн газрын хувь оролцоо	618,527,654.57	558,545,746.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	324,335,506.94	324,335,506.94
51101	Өмч: - төрийн	324,335,506.94	324,335,506.94
512	Хуримтлагдсан үр дүн	181,989,721.29	122,007,812.99
51210	Өмнөх үеийн үр дүн	6,237,884.43	181,989,721.29
51220	Тайлант үеийн үр дүн	175,751,836.86	-59,981,908.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	112,202,426.34	112,202,426.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	619,026,615.85	558,545,746.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,113,630,855.50	997,961,840.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	150,826,455.50	59,750,740.50
120	Нийтлэг татварын бус орлого	150,826,455.50	59,750,740.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	150,791,455.50	59,750,740.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,959,100.00	49,348,990.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	123,832,355.50	10,401,750.50
120009	Бусад орлого	35,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	962,804,400.00	938,211,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	914,642,600.00	932,135,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	914,642,600.00	932,135,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,161,800.00	6,076,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,562,000.00	5,450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,599,800.00	626,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	937,879,018.64	1,057,943,748.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	937,879,018.64	1,057,943,748.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885,685,417.92	961,055,456.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	559,648,106.85	593,513,403.22
210101	Үндсэн цалин	487,253,342.99	451,337,487.77
210102	Нэмэгдэл	60,446,500.00	121,658,602.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,948,263.86	20,517,313.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,381,461.28	77,810,872.79
210201	Тэтгэврийн даатгал	46,119,961.28	53,947,028.82
210202	Тэтгэмжийн даатгал	6,065,400.00	6,008,900.00
210203	ҮОМШ өвчний даатгал	4,852,300.00	4,787,229.68
210204	Ажилгүйдлын даатгал	1,213,100.00	1,188,027.71
210205	Эрүүл мэндийн даатгал	12,130,700.00	11,879,686.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,603,144.88	40,037,366.65
210301	Гэрэл цахилгаан	2,619,464.88	2,911,255.65
210302	Түлш, халаалт	33,791,670.00	34,932,411.00
210303	Цэвэр, бохир ус	2,192,010.00	2,193,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,347,145.40	78,991,169.95
210401	Бичиг хэрэг	9,553,863.24	13,425,232.13
210402	Тээвэр, шатахуун	18,370,200.00	28,038,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	10,344,347.11	11,240,820.88
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,847,683.58	26,167,116.94
210408	Бараа материал акталсны зардал	51,051.47	0.00
2105	Нормативт зардал	38,414,671.29	34,370,705.84
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,548,571.29	31,741,832.84
210502	Хоол, Хүнс	2,347,000.00	2,628,873.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,519,100.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,564,068.00	22,177,345.76
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	991,968.00	5,156,750.00
210604	Урсгал засвар	9,572,100.00	17,020,595.76
2107	Томиллолт, зочны зардал	18,848,000.00	21,115,500.00
210702	Дотоод албан томиллолт	18,848,000.00	21,115,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,915,625.00	15,341,505.00

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	346,000.00	11,473,465.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	973,850.00	938,540.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,649,700.00	1,649,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,975.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	63,100.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	688,000.00	1,205,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,963,195.22	77,697,587.73
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	898,000.00	1,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	70,065,195.22	76,597,587.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,193,600.72	96,888,291.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,350,000.00	23,963,041.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	17,207,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,350,000.00	6,755,141.60
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,843,600.72	72,925,250.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,843,600.72	72,925,250.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	175,751,836.86	-59,981,908.30
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	175,751,836.86	-59,981,908.30

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	324,335,506.94	112,202,426.34	181,989,721.29	0.00	618,527,654.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,335,506.94	112,202,426.34	181,989,721.29	0.00	618,527,654.57
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-59,981,908.30	0.00	-59,981,908.30
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	324,335,506.94	112,202,426.34	122,007,812.99	0.00	558,545,746.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	989,798,500.00	987,560,090.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,994,100.00	49,348,990.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,994,100.00	49,348,990.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,959,100.00	49,348,990.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,959,100.00	49,348,990.00
120009	Бусад орлого	35,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	962,804,400.00	938,211,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	914,642,600.00	932,135,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	914,642,600.00	932,135,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,161,800.00	6,076,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,562,000.00	5,450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,599,800.00	626,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	948,057,984.00	950,759,970.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	948,057,984.00	950,759,970.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	895,864,383.28	853,871,678.14
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	538,230,075.32	593,474,025.78
210101	Үндсэн цалин	482,585,422.43	451,298,110.33
210102	Нэмэгдэл	45,109,020.96	121,658,602.02
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	10,535,631.93	20,517,313.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,339,908.97	78,309,834.07
210201	Тэтгэврийн даатгал	79,089,410.99	54,445,990.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,336,698.25	6,008,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,062,638.58	4,787,229.68
210204	Ажилгүйдлийн даатгал	260,429.41	1,188,027.71
210205	Эрүүл мэндийн даатгал	9,590,731.74	11,879,686.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,603,144.88	40,037,366.65
210301	Гэрэл, цахилгаан	2,619,464.88	2,911,255.65
210302	Түлш, халаалт	33,791,670.00	34,932,411.00
210303	Цэвэр, бохир ус	2,192,010.00	2,193,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,066,876.11	42,999,652.88
210401	Бичиг хэрэг	13,920,100.00	10,258,600.00
210402	Тээвэр, шатахуун	30,820,200.00	16,540,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,636,347.11	11,419,020.88
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,510,229.00	4,662,032.00
2105	Нормативт зардал	44,652,385.00	18,379,413.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,521,385.00	15,750,540.00
210502	Хоол, хүнс	2,131,000.00	2,628,873.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	97,757,768.00	42,210,845.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,940,068.00	25,461,200.00

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	13,817,700.00	16,549,645.76
2107	Томилолт, зочны зардал	18,848,000.00	21,115,500.00
210702	Дотоод албан томилолт	18,848,000.00	21,115,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,468,225.00	16,245,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	346,000.00	11,723,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	973,850.00	938,540.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,649,700.00	1,649,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,975.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	63,100.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	688,000.00	1,205,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	552,600.00	654,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	898,000.00	1,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	898,000.00	1,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,193,600.72	96,888,291.86
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	22,500,000.00	48,199,290.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	22,500,000.00	48,199,290.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,350,000.00	23,963,041.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	17,207,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,350,000.00	6,755,141.60
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,343,600.72	24,725,960.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,343,600.72	24,725,960.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	41,740,516.00	36,800,120.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,740,516.00	36,780,120.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,740,516.00	36,780,120.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,740,516.00	36,780,120.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,740,516.00	36,780,120.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-41,740,516.00	-36,780,120.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	20,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	20,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		932,135,100.00	908,538,839.74	23,596,260.26
УРСГАЛ ЗАРДАЛ		932,135,100.00	908,538,839.74	23,596,260.26
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		908,377,200.00	885,025,798.14	23,351,401.86
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		600,888,400.00	593,378,265.78	7,510,134.22
Үндсэн цалин	21010100	480,518,900.00	451,298,110.33	29,220,789.67
Нэмэгдэл	21010200	100,646,500.00	121,658,602.02	-
Унаа хоолны Хөнгөлөлт	21010200	19,723,000.00	20,421,553.43	-698,553.43
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		81,120,000.00	78,279,594.07	2,840,405.93
Тэтгэврийн даатгал	21020100	57,084,400.00	54,415,750.10	2,668,649.90
Тэтгэмжийн даатгал	21020200	6,008,900.00	6,008,900.00	0.00
ҮОМШӨ-ний даатгал	21020300	4,807,100.00	4,787,229.68	19,870.32
Ажилгүйдлийн даатгал	21020400	1,201,800.00	1,188,027.71	13,772.29
Эрүүл мэндийн даатгал	21020500	12,017,800.00	11,879,686.58	138,113.42
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		40,524,900.00	40,037,366.65	487,533.35
Гэрэл, цахилгаан	21030100	3,100,000.00	2,911,255.65	188,744.35
Түлш, халаалт	21030200	35,231,200.00	34,932,411.00	298,789.00
Цэвэр, бохир ус	21030300	2,193,700.00	2,193,700.00	0.00
Хангамж, бараа материалын зардал		43,402,600.00	42,909,652.88	492,947.12
Бичиг хэрэг	21040100	10,286,900.00	10,258,600.00	28,300.00
Тээвэр, шатахуун	21040200	15,561,900.00	16,040,000.00	-478,100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21040300	12,205,800.00	11,419,020.88	786,779.12
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21040500	250,000.00	120,000.00	130,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21040600	5,098,000.00	5,072,032.00	25,968.00
Нормативт зардал		22,981,400.00	18,379,413.00	4,601,987.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21050100	20,281,400.00	15,750,540.00	4,530,860.00
Хоол, хүнс	21050200	2,700,000.00	2,628,873.00	71,127.00
Эд хогшил, урсгал засварын зардал		74,737,800.00	73,580,965.76	1,156,834.24
Багаж, техник, хэрэгсэл	21060100	32,000,000.00	31,570,120.00	429,880.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21060300	26,000,000.00	25,461,200.00	538,800.00
Урсгал засвар	21060400	16,737,800.00	16,549,645.76	188,154.24
Томилолт, зочны зардал		21,147,100.00	21,115,500.00	31,600.00
Дотоод албан томилолт	21070200	21,147,100.00	21,115,500.00	31,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		22,475,000.00	16,245,040.00	6,229,960.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21080100	16,423,500.00	11,723,000.00	4,700,500.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21080200	1,199,800.00	938,540.00	261,260.00
Даатгалын үйлчилгээ	21080300	1,649,700.00	1,649,500.00	200.00
Тээврийн хэрэгслийн татвар	21080400	200,000.00	0.00	200,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	21080500	75,000.00	75,000.00	0.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21080600	1,727,000.00	1,205,000.00	522,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21080900	1,200,000.00	654,000.00	546,000.00

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал		1,100,000.00	1,100,000.00	0.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	21090200	1,100,000.00	1,100,000.00	0.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		23,757,900.00	23,513,041.60	244,858.40
Бусад урсгал шилжүүлэг		23,757,900.00	23,513,041.60	244,858.40
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21320700	17,207,900.00	17,207,900.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21320900	6,550,000.00	6,305,141.60	244,858.40
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		932,135,100.00	908,558,839.74	0.00
Улсын төсвөөс санхүүжих	13100100	932,135,100.00	908,558,839.74	23,576,260.26
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	20,000.00	-20,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,076,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ	6,076,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,626,000.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	95,760.00
Унаа хоолны Хөнгөлөлт	95,760.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,240.00
Тэтгэврийн даатгал	30,240.00
Хангамж, бараа материалын зардал	500,000.00
Тээвэр, шатахуун	500,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00
Тавилга	5,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	450,000.00
Бусад урсгал шилжүүлэг	450,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	450,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,076,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	6,076,000.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,450,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	626,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, түлш халаалтын зардал болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газар нь “Хууль тогтоомжийг сахиулан, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчныг дэмжиж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 937,879.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,068.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,551.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,480.9 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө болон материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	20.0	
Авлага	39.4	-	
Бараа материал	145,375.7	122,731.7	- 22,644.0
Үндсэн хөрөнгө	473,611.5	435,794.1	- 37,817.5
Нийт хөрөнгө	619,026.6	558,545.7	- 60,480.9
Өглөг	499.0	-	
Засгийн газрын оруулсан капитал	324,335.5	324,335.5	-
Хуримтлагдсан үр дүн	181,989.7	122,007.8	- 59,981.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	112,202.4	112,202.4	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	618,527.7	558,545.7	- 59,981.9

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 435,794.1 мянган төгрөг болж 37,817.5 мянган төгрөгөөр, бараа материалын дансны үлдэгдэл 122,731.7 мянган төгрөг болж, 22,644.0 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурахад тайлант оны 76,597.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлжээ. Мөн тайлант онд бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй 2,000.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 36,780.1 мянган төгрөг, нийт 38,780.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 115,669.0 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 113,430.6 мянган төгрөгөөр буюу 91.6 хувиар буурч, тайлант үед 10,401.8 мянган төгрөг болсон байна.

Нийт зардал өмнөх оноос 120,064.7 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон төвлөрүүлэх шилжүүлгийн зардлууд байна. Тодруулбал өмнөх оноос цалин хөлсний зардал 33,865.3 мянган төгрөгөөр, төвлөрүүлэх шилжүүлгийн зардал 36,081.6 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,339,319.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,339,319.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 437,497.4 мянган төгрөгөөр бууруулж 901,822.4 мянган төгрөгөөр баталсан байна. Харин төсвийн тодотголоор тус байгууллагын төсөв 30,312.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 932,135.1 мянган төгрөг болсон байна. Төсвийн төслөөс тайлант оны төсөв нь 437,497.4 мянган төгрөгөөр бага дүнгээр батлагдаж, төсөв 30,312.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн боловч тухайн байгууллагын 2021 онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 74 арга хэмжээ бүхий “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” 88.5 хувьтай хэрэгжсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 932,135.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 932,135.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 932,135.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны 49,349.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 908,558.8 мянган төгрөгийг зарцуулж, дээд шатны төсөв захирагчид 48,199.3 мянган төгрөгийг, улсын төсөвт 1,149,700 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 908,538.8 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 10,350.5 мянган төгрөгөөр, нормативт зардал 4,602.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 6,230.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 6,076.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 6,076.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын хяналт шалгалтын үйл ажиллагаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан 5 дугаар зүйлийн 5.1-д заалтад заасан төлөвлөгөөт шалгалт, төлөвлөгөөт бус шалгалт болон гүйцэтгэлийн шалгалт гэсэн 3 төрлийн шалгалтаас бүрддэг байна.

Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга М.Чинзоригийг ажлаас үндэслэлгүй халсан болохыг Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 122/ШШ/2020/0011 дүгээр шийдвэрээр тогтоосон бөгөөд төсвийн захирагч ажилд эргүүлэн томилох, ажилгүй байсан хугацааны цалин хөлс 5,252.2 мянган төгрөгийг төсвөөс олгохоор шийдвэрлэсэн байна. Харин ажилгүй байсан хугацааны цалин хөлсөнд олгосон 5,252.2 мянган төгрөгийг буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлэх тухай албан шаардлагыг МХЕГ-т хүргүүлсэн боловч төлөгдөөгүй байна.

Мөн дээрх шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд М.Чинзоригийг ажилд эргүүлэн томилоогүй байна. М.Чинзоригийн 2020 оны 4 сарын 30-ны өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн хариуцагчийн зөвшөөрлийг Сүхбаатар аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 03 сарын 26-ны өдрийн 147/ШШ/2021/00139 дугаар захирамжаар баталсан байна. Энэхүү захирамжийг үндэслэн Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газраас ажилгүй байсан хугацааны цалинг олгож, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн байна. Харин буруутай шийдвэр гаргасан холбогдох этгээд байгууллагад учирсан хохирлыг арилгаагүй байна. Иймд энэ асуудлыг Үндэсний аудитын газарт уламжилж, холбогдох мэдээлэл, судалгааг хүргүүлээ.

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын дотоод хяналтын ажлыг хэсэг байгууллагын 2020, 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, албан хаагчдын цалин хөлс, албан томилолт, шатахууны зарцуулалт, ариутгалын орлогын бүрдүүлэлт, цар тахлын үеийн хандив тусламжийн орлого, зарцуулалтын хэрэгжилтэд дотоод хяналт хийж, илэрсэн зөрчлийг 2021 оны 9 сарын 06-ны өдрийн 220 дугаартай албан бичгээр Сүхбаатар аймгийн Прокурорын газарт шилжүүлсэн байна. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн уг асуудал хянагдах шатандаа байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 3 арга хэмжээний хэрэгжилт 88.5 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.5 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 138 мэдээллээс хугацаандаа оруулсан 125 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 11, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасан байна. Иймд энэ тогтоолын хэрэгжилт мэргэжлийн хяналтын байгууллагад хамааралгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 3,290.3 мянган төгрөгийн 1 акт тогтоосноос 2,890.3 мянган төгрөг барагдсан, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар үндсэн хөрөнгө, түлш халаалтын зардал болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой нийт 2,000.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 203 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

3. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд “Цайрт минерал” ХХК-иас нэг бүр нь 450.0 мянган төгрөгийн үнэтэй 3 принтер, 650.0 мянган төгрөгийн үнэтэй 1 принтер, нийт 2,000.0 мянган төгрөгийн үнэтэй 4 принтерийг хандиваар авсан нь Төсвийн тухай хуулийн 25.2, 25.5.1 дэх заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагаас хандив авахгүй байх, Төсвийн тухай хуулийн 25.2, 25.5.1 дэх заалтыг дагаж мөрдөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газар	3	2.0	-	-	-	-	-	-	3	2.0